МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

# ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ХУУЛИЙН ХЭЛТСИЙН АХЛАХ ШИНЖЭЭЧ ЦЭРЭНМИНЖИНГИЙН БАТЧИМЭГИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

**БАЙГУУЛЛАГЫН НЭР: ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ**

**Тайлантай танилцсан:**
**ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ** ........................................ **/Б.БАТ-ЭРДЭНЭ/**

**Тайлан гаргасан:**
**ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ХУУЛИЙН ХЭЛТСИЙН АХЛАХ ШИНЖЭЭЧ** ........................................ **/Ц.БАТЧИМЭГ/**

Тэмдэг

2025-12-05
(огноо)

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын*
*2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

**ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ХУУЛИЙН ХЭЛТСИЙН ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ ХАРИУЦСАН АХЛАХ ШИНЖЭЭЧ ЦЭРЭНМИНЖИНГИЙН БАТЧИМЭГИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт хувиар |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Стратегийн зорилт 5.<br>2.5.5.3.салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, эрх зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх** | | | | | | | |
| 1 | **Арга хэмжээ 1.1.**“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн Зорилт 3.6-ын “3.6.1-д газрын харилцаа, хот байгуулалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хотуудын зэрэглэлийг тогтоосон байна.” гэж, “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний “2.1.1.9.Хот төлөвлөлтийн бичиг баримтыг боловсруулахад оршин суугч, аж ахуйн нэгжийн саналыг тусгах, хөрөнгө оруулалттай уялдсан хот байгуулалтын бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хууль, эрх зүйн шинэчлэлийн бэлтгэл ажлыг эхлүүлэх” гэж, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр | Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах үйл ажиллагааны үе шатны ажлуудыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу зохион байгуулсан тоогоор | СТ-1. Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн тухайд: Хууль тогтоомжийн тухай хуулийн 8.1.1-д заасан үе шатны ажил хийгдсэн ажлын тоо-1<br>СТ-2. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын ажлын даалгавар баталсан тоо-1 | ЗТ-2. Хуулийн тогтоомжийн тухай хуулийн 8.1.3-8.1.6-д заасан үе шатны ажлыг хийж гүйцэтгэхэд тухай бүр мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлсэн байна. | 1.Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2024 оны 79 дүгээр тушаалаар Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах Ажлын хэсгийг байгуулсан.<br><br>Хуулийн төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ үзүүлэх гүйцэтгэгчээр “Хууль зүйн бичигт хүрээлэн” НҮТББ шалгарч, 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдөр зөвлөх үйлчилгээний 2024/192 тоот гэрээг байгуулан ажиллаж байна. Хуулийн төслийг боловсруулах ажлын хүрээнд “Хот байгуулалтын эрх зүйн зохицуулалт, тулгамдаж буй асуудал” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулсан.<br><br>Улсын Их Хурлаас Монгол Улсын Засгийн газрын тухай хууль болон Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбогдуулан Засгийн газар шинээр эмхлэн зохион байгуулагдсан тул Хот байгуулалт, барилга, орон | 2025.01.01<br>-<br>2025.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “4.2.4.3.Хот байгуулалт, барилга, газрын талаарх холбогдох хуулийн уялдааг сайжруулж, төлөвлөлтөд суурилсан хот байгуулалтын тогтолцоог бий болгон, хотын ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн төлөвлөгөөний дагуу газрын зөвшөөрлийг олгож, зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хуулийн хариуцлагыг чангатгана.” гэж заасан зорилтуудын хүрээнд салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлнэ. | | | | сууцжуулалтын сайдын 2025 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 206 дугаар тушаалаар Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан. Хуулийн төсөл боловсруулах ажлын явц, агуулгыг мөн оны 09 дүгээр сарын 04-ний өдөр Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан, сайдын зөвлөх И.Баттөгс, Төрийн нарийн бичгийн дарга М.Баяраа болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулсан. Хуулийн төслийн үзэл баримтлалын анхны төслийг боловсруулж, 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 02/3384 тоот албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн сайд, Сангийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч, “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ болон “Монголын архитекторуудын эвлэл” ТББ, “Монголын барилгын зураг төсөл зохиогчдын холбоо” ТББ-д тус тус хандаж тус тус санал авахаар хүргүүлсэн.<br><br>Хуулийн төслийн үзэл баримтлалыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгаланаар 10 дугаар сарын 27-ны өдөр батлуулсан. Түүнчлэн Хууль зүй, дотоод хэргийн сайдаар батлуулахаар 10 дугаар сарын 29-ний өдрийн 01/4006 тоот албан бичгээр хүргүүлсэн бөгөөд тус яамнаас үзэл баримтлалыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаар мөн батлуулах нь зүйтэй гэсэн чиглэл ирүүлсний дагуу үзэл баримтлалын төслийг Монгол Улсын | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаар батлуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газар руу 2025 оны 11 дүгээр 27-ны өдрийн 01/4361 тоот албан бичгээр хүргүүлсэн болно.<br><br>2.Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн хуралдаанд тухай бүр оролцож, мэргэжил арга зүйн туслалцаа дэмжлэг үзүүлж ажилласан.<br>Хуулийн төслийг боловсруулах Зөвлөх үйлчилгээ авах Ажлын даалгаварыг хянаж, нарийн бичгийн даргатай хамтран эцэслэн батлуулсан болно. | | |
| 2 | **Арга хэмжээ 1.2.**"Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"-ын 3.4.3.2-т "Нийслэлийн хүн амын төвлөрлийг тархаан байршуулах зорилгоор дагуул хотуудыг төлөвлөж, бүс нутгийг өндөр хурдны авто зам, эрчим хүч, инженерийн барилга байгууламжаар хангаж холбоно." гэж, "Монгол Улсын Их Хурлаас баталсан "Алсын хараа-2050" урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 9.3.1-т "Улаанбаатар хотын төвлөрөл, суурьшсан нутаг дэвсгэрийн тэлэлт, хязгаарлалт, газар зохион байгуулалт, авто замын сүлжээ, нийтийн тээвэр, газар доорх орон зай гэх мэт шаардлагатай төлөвлөлтийг тооцон хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, | Үе шатны ажлуудыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу зохион байгуулсан тоогоор | Үе шатны ажлуудыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу зохион байгуулсан байна | Мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлсэн байна. | "Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-ний баримт бичгийг 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 2 дугаар тэмдэглэлээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтсон.<br><br>Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн бөгөөд УИХ-ын 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар "Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-ний төслийг хэлэлцэх эсэхийг хэлэлцсэн бөгөөд Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцэхээр шийдвэрлэсэн.<br>2025 оны 12 дугаар сарын байдлаар "Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртлэх хөгжлийн ерөнхий | 2025.01.01<br>-<br>2025.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэдээллийн нэгдсэн системд холбон хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлнэ" гэж , "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн Зорилго 9-д "Амьдрахад таатай, байгаль орчинд ээлтэй, хүн төвтэй ухаалаг хот болгон хөгжүүлнэ" гэж, "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 1.1.1.1-д ""20 минутын хот" буюу нийгмийн дэд бүтцийн хүртээмжийг зохистой түвшинд хүргэх бодлогын баримт бичгийг боловсруулж, түүнд суурилсан "Нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 2040" болон бусад хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, батлуулна" гэж тус тус тусгасаны дагуу "Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлж, батлуулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлсэн байна. | | | | төлөвлөгөө"-ний баримт бичгийг Төрийн байгууллалтын байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэхээр бэлтгэгдэж байна. | | |
| 3 | **Арга хэмжээ 1.3.**УИХ-ын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын жагсаалтыг гаргаж нэгтгэн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ. | Явуулсан албан бичгийн тоогоор | Албан бичиг-2 | Албан бичиг хүргүүлсэн байна. | Улсын Их Хурлын хаврын чуулганы нэгдсэн хуралдаанаар Үндэсний орон сууцжуулалтын тухай анхдагч хуулийн төсөл, Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Барилгын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Орон сууцны тухай | 2025.01.01 - 2025.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон “Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг, мөн Улсын Их Хурлын намрын чуулганы нэгдсэн хуралдаанаар тус яамнаас хэлэлцүүлэх хууль тогтоомжийн төслүүд (Үндэсний орон сууцжуулалтын тухай анхдагч хуулийн төсөл, Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Барилгын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл)-ийн жагсаалтыг саналыг холбогдох бодлогын газруудаас авч, нэгтгэн удирдлагуудад танилцуулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тухай бүр хүргүүлсэн. | | |
| 4 | **Арга хэмжээ 1.4.**Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын жагсаалтыг гаргаж нэгтгэн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ. | Явуулсан албан бичгийн тоогоор | Албан бичиг-4 | Албан бичиг хүргүүлсэн байна. | Засгийн газрын 2025 оны 20 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын хуралдааны журам”-ын 4.3-т заасны дагуу Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамнаас 2025 оны I дүгээр улиралд “Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, “Цагааннуур чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай” Засгийн газрын тогтоолын төсөл, “Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс”-ийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай” Засгийн газрын тогтоол, “Хөдөө, орон нутагт ипотекийн 3 хувийн хүүгийн татаас олгох тухай” Засгийн газрын тогтоолын төсөл, “Барилгын материал бүтээгдэхүүний аюулгүй байдлын техникийн зохицуулалт” зэрэг нийт 5 асуудал, мөн оны II дугаар улиралаар “Нийт аж ахуйн үйлчилгээний салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төсөл, Нийтийн аж ахуйн салбарт гадаадын | 2025.01.01 - 2025.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зээл, тусламжийн хөрөнгөөр дамжуулан зээлдүүлэх гэрээгээр хэрэгжсэн болон одоо хэрэгжиж байгаа төслүүдийн зээл, зээлийн хүүгийн эргэн төлөлтийн талаар 2 асуудал, мөн оны III улиралаар “Нийт аж ахуйн үйлчилгээний салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төсөл, Нийтийн аж ахуйн салбарт гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр дамжуулан зээлдүүлэх гэрээгээр хэрэгжсэн болон одоо хэрэгжиж байгаа төслүүдийн зээл, зээлийн хүүгийн эргэн төлөлтийн талаар, “Журам батлах тухай” Засгийн газрын тогтоолын төсөл (Амины орон сууцанд татаас олгох), Үндэсний орон сууцжуулалтын тухай анхдагч хуулийн төсөл, Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Барилгын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Орон сууцны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл зэрэг нийт 7 асуудал, мөн оны IY улиралаар Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын Бүгд Найрамдах Солонгос Улсад хийх айлчлалын талаар, “Дүрэм шинэчлэн батлах тухай” (Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм) Засгийн газрын тогтоолын төсөл, “Техникийн зохицуулалт батлах тухай” (Барилгын материал, бүтээгдэхүүний аюулгүй байдлын техникийн зохицуулалт батлах тухай) Засгийн газрын тогтоолын төсөл, “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” (20 минутын хот хөгжлийн төвийн талаар авах зарим арга хэмжээний тухай”) Засгийн газрын тогтоолын төсөл, “20 минутын хотын үзэл баримтлал батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, “Барилгын салбар үүсч хөгжсөний 100 жилийн ойг тэмдэглэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | өнгөрүүлэх тухай” Засгийн газрын тогтоолын төсөл, “Журам батлах тухай” (Түрээсийн орон сууцны журам) Засгийн газрын тогтоолын төсөл, Хүн амыг ундны цэвэр ус, ариун цэврийн байгууламжаар тэгш хангах, хүртээмжийн ялгааг бууруулах зорилгоор улсын хэмжээнд нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах талаар, Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш, эмч нарт зориулсан орон сууцны хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийн талаар, “Дүрэм батлах тухай” (Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрэм) болон Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл зэрэг нийт 16 асуудал, нийт 30 гаруй асуудлын жагсаалтыг холбогдох нэгжүүдээс санал авч нэгтгэн, тухай бүр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тус тус хүргүүлсэн. | | |
| 5 | **Арга хэмжээ 1.5.**Хянаж, дугаар олгосон захирамжлалын болон зохион байгуулалтын баримт бичгийн бүртгэлийг хөтлөнө. | Хянаж, дугаар олгосон захирамжлалын болон зохион байгуулалтын баримт бичгийн тоо | Тайлан-1 | Тайлан-1 | 1.Холбогдох хууль тогтоомжид зааж, эрх олгосоны дагуу боловсруулсан дараах тушаалын төслүүдийн хууль, эрх зүйн үндэслэл болон найруулгыг тушаал, шийдвэр боловсруулах аргачлалын дагуу Захиргааны ерөнхий хууль болон холбогдох салбарын хуулиудад тус тус нийцүүлэн хянаж, саналуудыг тусган ажиллалаа. Мөн бүртгэж, дугаар олгосон.<br>Үүнд:<br>-Сайдын тушаал 258;<br>-Төрийн нарийн бичгийн даргын батлан гаргах яамны үйл ажиллагаатай холбоотой А тушаалын төсөл 159;<br>-Хүний нөөцийн үйл ажиллагаа, хөрөнгө гаргах тухай болон гадаад томилолттой холбоотой Б тушаалын төсөл 206;<br>-нийт 623 тушаалын төсөл.<br>2.Яамнаас иргэн, хуулийн этгээдтэй байгуулах 348 гэрээ, хэлцлийн төслийг мөн хууль тогтоомжид нийцүүлэн хянаж, бүртгэж тус тус дугаар олгосон. | 2025.01.01<br>-<br>2025.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | **Арга хэмжээ 1.6.**Хот байгуулалтын салбарт нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний шинээр болон шинэчлэн боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулах үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлнэ. | Тайлан-1 | - | Тайлан-1 | 1.Салбарын хуулиар эрх олгосны дагуу ХОт байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын баталж, , нийтээр мөрдүүлж буй улсын нэгдсэн санд бүртгэлтэй захиргааны хэм хэмжээний актад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулж “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-тэй хамтран БХБЯ-ны цахим архивд хадгалагдаж буй Сайдын тушаалтай нэг бүрчлэн тулгалт хийн шалгаж, нэгтгэн тайланг боловсруулж, холбогдох саналын хамтаар ХЗДХЯ-нд хүргүүлсэн.<br>2.Ерөнхий сайдын 2025 оны 64 дүгээр захирамжийн 2 дугаар хавсралтаар баталсан “Авлигатай тэмцэх, авлига, албан тушаалын гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг арилгах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 3.1-д заасан тусгай зөвшөөрлийн тоог цөөлөх арга хэмжээний хүрээнд барилгын салбарын хэмжээнд хуулиар эрх олгогдоогүй дүрэм, журам болон бусад захиргааны хэм хэмжээний актуудыг хамтран шийдвэрлэх ажлын хүрээнд улсын нэгдсэн санд бүртгэлгүй, хуульд тусгаж эрх олгох, нийтээр дагаж мөрдүүлэх шаардлагатай актын судалгааг мөн хуульд нийцүүлэх, шинэчлэн боловсруулах шаардлагатай актын судалгааг тус тус ЗГХЭГТ-т хүргүүлэн хамтран ажиллаж байна.<br>3.Тайлант хугацаанд 8 хэм хэмжээний актын төслийг бодлогын газраас боловсруулан ирүүлсэнийг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлж, бүртгэх эрх бүхий байгууллагад бүртгүүлэхээр хүргүүлсэн. | 2025.01.01<br>-<br>2025.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | **Арга хэмжээ 1.7.**Яамны дотоод үйл ажиллагаанд мөрдөх дүрэм, журам, гэрээг шинээр болон шинэчлэн боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах баримт бичгийг боловсруулах үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлнэ. | Тайлан-1 | - | Тайлан-1 | Хөдөлмөрийн дотоод журам, Шагналын журам болон холбогдох бусад журам, тушаалын төсөл (Сайд, Төрийн нарийн бичгийн даргын)-үүд болон албан бичиг боловсруулах үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлж, эцэслэн хянаж боловсруулсан. | 2025.01.01 - 2025.12.31 | 100% |
| 8 | **Арга хэмжээ 1.8.**Бусад төрийн захиргааны төв байгууллагаас ирүүлсэн хууль, УИХ-ын тогтоол, Засгийн газрын тогтоолын төсөлд санал боловсруулж, хүргүүлсэн байна. | Албан бичгийн хариуг явуулсан тоогоор | Албан бичгийн хариу саналыг хүргүүлсэн байна. | Албан бичгийг хугацаанд нь төлөвлөж, саналыг тухай бүр хүргүүлсэн байна. | Тайлант хугацаанд иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллага, түүнчлэн Засгийн газар, Засгийн газрын яам, агентлагаас нийт 207 бичиг ирснээс хариутай 203 албан бичгүүдэд тус тус хариу санал бэлтгэж, удирдлагад танилцуулан, хуулийн хугацаанд шийдвэрлэсэн бөгөөд холбогдох байгууллагуудад хүргүүлсэн болно.<br>Үүнд:<br>Хуулийн төсөл-21;<br>ЗГ-ын тогтоолын төсөл-180;<br>Хүн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл гомдол-4 | 2025.01.01 - 2025.12.31 | 100% |
| 9 | **Арга хэмжээ 1.9.** Төрийн албаны зөвлөлийн Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны салбар зөвлөлийн гишүүний үүрэгт ажил | Тусгай шалгалт болон холбогдох бусад үйл ажиллагаа явуулсан ажлын үр дүнгийн биелэлтээр | Тусгай шалгалтуудыг зохион байгуулж, холбогдох бусад шийдвэрүүдийг албажуулсан байна. | Салбар зөвлөлийн үйл ажилагааг хэвийн, тогтмол явуулсан байна. | Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 59 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 6.1-д заасны дагуу Төрийн албаны зөвлөлийн Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх Салбар зөвлөлийн 2024 оны жилийн эцсийн үйл ажиллагааны тайланг 2025.01.16-ны өдрийн 11/187 тоот албан бичгээр Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн. Төрийн албаны зөвлөлийн Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх Салбар зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 12-ний өдрийн ээлжит хурлыг зохион байгуулж, 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулсан. Төрийн албаны | 2025.01.01 - 2025.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-ын дагуу Төрийн албаны эрхэлсэн түшмэлийн зэрэг дэв шинээр болон ахиулан олгох албан хаагчдын мэдээллийг нэгтгэн 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01/170 тоот албан бичгээр Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн. Төрийн албаны зөвлөлийн 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн “Хүний нөөцийн үйл ажиллагаанд хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 479 дүгээр тогтоол, ажлын хэсгийн тайлан, дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг нэгтгэн гаргаж 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 03/355 дугаар албан бичгээр Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн. Төрийн албаны зөвлөлийн даргын 2024 оны 159 дугаар тушаал 2025 оны “Төрийн албаны өдөр”-ийг угтан зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөө болон 2025 оны 15 дугаар тушаал “Шинэтгэлээр түүчээлсэн салбар зөвлөл аяныг зохион байгуулах тухай”-уудаар баталсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх зорилгоор Төрийн нарийн бичгийн даргаар яамны хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулсан. Төрийн нарийн бичгийн даргын баталсан “Төрийн албаны өдөр-2025”-ийг угтах арга хэмжээний төлөвлөгөө болон “Шинэтгэлээр түүчээлсэн салбар зөвлөл” аяныг зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан төрийн албан хаагчдын төрийн албанд ажиллахын давуу талыг илэрхийлсэн 3 видео контентийг ТЗУГ-тай хамтран бэлтгэн яамны цахим сүлжээ болон Төрийн албаны зөвлөлийн цахим | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сүлжээнд байршуулж олон нийтэд хүргэсэн. "Төрийн байгууллагын мэдээллийн технологийн чиг үүрэг хэрэгжүүлдэг хүний нөөцийн бүрдүүлэлт, сургалт, хөгжлийн бодлогын хэрэгжилт, үр дүн" сэдвээр хийсэн хүний нөөцийн аудитын дүгнэлт, зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн албаны зөвлөлийн Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх Салбар зөвлөлийн даргаар 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр батлуулсан. Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам"-ын 4.2-т заасны дагуу эрхэлсэн түшмэлийн 3 сул орон тоо, ахлах түшмэлийн 5 сул орон тоо, дэс түшмэлийн 10 сул орон тоог яамны цахим хуудас болон зөвлөлийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж, албан тушаалын тусгай шаардлагыг хангаж буй иргэдийг томилж, нөхөгдөөгүй сул орон тооны сонгон шалгаруулалтын явуулах захиалгыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлэн ажилласан.<br>Тус яамны эрхэлсэн түшмэлийн албан тушаалын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Төрийн захиргааны удирдлагын газрын Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн даргын сул орон тоог нөхөх шалгалт, сонгон шалгаруулалтыг зохион байгуулах тухай 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 03/2010 дугаартай албан бичиг, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий санхүүчийн сул орон тоог нөхөх шалгалт, сонгон шалгаруулалтыг зохион байгуулах тухай 2025 оны 04 дүгээр | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сарын 01-ний өдрийн 03/1106 дугаартай албан бичгийг Төрийн албаны зөвлөлд тус тус хүргүүлсэн байна.<br>Төрийн албаны зөвлөлийн Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх Салбар зөвлөлийн 2024 оны “Ажлын хэсэг байгуулах” тухай 03 дугаар тогтоолоор байгуулагдсан тусгай шалгалт зохион байгуулах ажлын хэсэг тус яамны гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх төрийн албаны тусгай шалгалтыг 2025 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр зохион байгуулж, шалгалт зохион байгуулсан тайланг салбарын зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн ээлжит хуралдаанд танилцуулж, салбар зөвлөлөөс сонгон шалгаруулалтад оролцсон 3 иргэнийг нэр дэвшүүлж, санал болгосон.<br>Төрийн албаны зөвлөлийн Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх Салбар зөвлөлийн 2025 оны “Ажлын хэсэг байгуулах” тухай 04 дүгээр тогтоолоор байгуулагдсан тусгай шалгалт зохион байгуулах ажлын хэсэг тус яамны гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх төрийн албаны тусгай шалгалтыг 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр зохион байгуулж, шалгалт зохион байгуулсан тайланг салбарын зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хуралдаанд танилцуулж, салбар зөвлөлөөс сонгон шалгаруулалтад оролцсон 3 иргэнийг нэр дэвшүүлж, санал болгосон. Төрийн албаны зөвлөлийн Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх Салбар зөвлөлийн 2025 оны “Ажлын хэсэг байгуулах” тухай 08 дугаар тогтоолоор байгуулагдсан тусгай шалгалт зохион байгуулах ажлын хэсэг | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тус яамны гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх төрийн албаны тусгай шалгалтыг 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулж, шалгалт зохион байгуулсан тайланг салбарын зөвлөлийн 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн ээлжит хуралдаанд танилцуулж, салбар зөвлөлөөс сонгон шалгаруулалтад оролцсон 5 иргэнийг нэр дэвшүүлж, санал болгосон. Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 03 дугаар тогтоолоор баталсан "Албан тушаалын тодорхойлолт батлах тухай нийтлэг журам"-ын дагуу төрийн захиргааны албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж Төрийн албаны зөвлөлийн хуралдаанд хэлэлцүүлж батлах зөвшөөрөл авахаар 2025.09.23-ны өдрийн 01/3615 дугаар албан бичгийг Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн. Төрийн албаны зөвлөлийн 2025.10.29-ний өдрийн ээлжит хуралдаанаар албан тушаалын тодорхойлолт, Төрийн албаны зөвлөлийн Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудлуудыг хэлэлцүүлсэн. Төрийн албаны зөвлөлийн 2025.10.29-ний өдрийн "Зөвшөөрөл олгох тухай" 458, 459, 460, 461 дугаар тогтоолууд албажиж, хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд ХББОСЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2025.11.19-ний өдрийн Б/199, Б/200, Б/201, Б/202 дугаар тушаалуудаар "Албан тушаалын тодорхойлолт"-ыг баталгаажуулсан. Архив албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн "Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтыг дүгнэх үзүүлэлт, аргачлал"-ын талаар мэдээлэл өгөх, арга зүйн сургалтад 2025 оны 09 дүгээр сарын | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 24-ний өдөр хамрагдаж, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны “Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт”-ын тайлан, мэдээг нэгтгэн гаргаж шалгуулан бүрэн хангалттай үнэлэгдсэн. Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн удирдлага, аудитын газраас 2025.11.06-09-ний өдрүүдэд хийгдсэн хүний нөөцийн гүйцэтгэлийн аудитын ажлын хүрээнд Төрийн албаны зөвлөлийн Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх салбар зөвлөлийн үйл ажиллагааны тайлан, судалгаа, холбогдох нотлох баримтуудыг нэгтгэн гаргаж хүргүүлсэн. Яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлттэй холбогдуулан Төрийн нарийн бичгийн даргын “Албан тушаалын тодорхойлолт”-ыг Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын дагуу шинэчлэн боловсруулж, холбогдох танилцуулга, мэдээллийг бэлтгэн 2025 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн 01/3067 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. | | |

**Хоёр.Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| № | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/28 дугаар тушаалаар байгуулсан “Сумын төвийн инженерийн дэд бүтэц, шугам сүлжээний 2 дугаар ээлжийн ажил (Төв аймаг, Эрдэнэ сум) арга хэмжээг зохион байгуулах Үнэлгээний хорооны гишүүн | Үнэлгээний хорооны хуралдаанд оролцсон тоогоор | Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн | Үнэлгээний хороооны үйл ажиллагаа, холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна. | Үнэлгээний хорооны хуралдаанд тухай бүр оролцож, мэргэжил, арга зүй туслалцаа үзүүлж ажилласан бөгөөд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан. | 2025.01.01 - 2025.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | зохион байгуулсан байдал | | | | |
| 2 | Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/33 дугаар тушаалаар байгуулсан "Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах цогц хөтөлбөр (Өвөрхангай аймгийн Хужирт, Бат-Өлзий, Бүрд, Богд сум), (Увс аймгийн Баруунтуруун, Наранбулаг, Хяргас) төсөл, арга хэмжээ"-ний гүйцэтгэгчийн сонгон шалгаруулах үүрэг бүхий Үнэлгээний хорооны гишүүн | Үнэлгээний хорооны хуралдаанд оролцсон тоогоор | Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулсан байдал | Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна. | Үнэлгээний хорооны хуралдаанд тухай бүр оролцож, мэргэжил, арга зүй туслалцаа үзүүлж ажилласан бөгөөд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан. | 2025.01.01 - 2025.12.31 | 100% |
| 3 | Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/29 дугаар тушаалаар байгуулсан XVIII.1.1.6 "Сумын төвийн инженерийн дэд бүтэц, шугам сүлжээний ажил /Хөвсгөл, Цагаан уул сум/ төсөл, арга хэмжээ"-ний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үүрэг бүхий Үнэлгээний хорооны гишүүн | Үнэлгээний хорооны хуралдаанд оролцсон тоогоор | Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулсан байдал | Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна. | Үнэлгээний хорооны хуралдаанд тухай бүр оролцож, мэргэжил, арга зүй туслалцаа үзүүлж ажилласан бөгөөд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан. | 2025.01.01 - 2025.12.31 | 100% |
| 4 | Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/22 дугаар тушаалаар байгуулсан Азийн хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ""Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах төсөл (МОН-3244/3245)"-ийг хэрэгжүүлж дуусч байгаатай холбогдуулан Захиалагчийн техникийн хяналтын зөвлөх үйлчилгээний төлбөр" төсөл, | Үнэлгээний хорооны хуралдаанд оролцсон тоогоор | Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн зохион | Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна. | Үнэлгээний хорооны хуралдаанд тухай бүр оролцож, мэргэжил, арга зүй туслалцаа үзүүлж ажилласан бөгөөд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан. | 2025.01.01 - 2025.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалтыг зохион байгуулах үүрэг бүхий Үнэлгээний хорооны гишүүн | | байгуулсан байдал | | | | |
| 5 | Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/18 дугаар тушаалаар байгуулагдсан "Дулааны шугам сүлжээний даралт өргөх насос станц №7-ын өргөтгөлийн барилга угсралтын ажил (Улаанбаатар, Хан-Уул дүүрэг) төсөл, арга хэмжээ"-ний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалтыг зохион байгуулах үүрэг бүхий Үнэлгээний хорооны гишүүн | Үнэлгээний хорооны хуралдаанд оролцсон тоогоор | Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулсан байдал | Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна. | Үнэлгээний хорооны хуралдаанд тухай бүр оролцож, мэргэжил, арга зүй туслалцаа үзүүлж ажилласан бөгөөд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан. | 2025.01.01 - 2025.12.31 | 100% |
| 6 | “Ажлын хэсэг байгуулах тухай” Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/81 дүгээр тушаалаар байгуулсан “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл” Төслийн нэгжийн Санхүүгийн ажилтныг сонгон шалгаруулах үүрэг бүхий Үнэлгээний хорооны гишүүн | Төслийн ажилтныг сонгон шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулсан тоогоор | Зохион байгуулсан тоо | Төслийн ажилтан сонгон шалгарсан байна. | Төслийн ажилтанг сонгон шалгаруулах үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу сонгон шалгаруулах зарыг хүргүүлж, холбогдох бусад үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан. | 2025.01.01 - 2025.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | Сайд, Төрийн нарийн бичгийн дарга болон нэгжийн дарга нараас өгсөн бусад үүрэг даалгаварын талаар | Өгсөн үүрэг даалгаврын тоогоор | | Үүрэг, даалгаварууд биелсэн байна. | Сайд, Төрийн нарийн бичгийн дарга, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга болон Хуулийн хэлтсийн даргаас тухай бүр өгсөн чиглэлийн дагуу хүний нөөцтэй холбоотой, мөн холбогдох бусад тушаал, албан бичгийн төслүүдийг тус тус боловсруулан, батлуулж ажилласан. Мөн нэгжүүдээс ирүүлсэн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх, танилцуулах асуудлыг хамтран боловсруулж, эцэслэн хянасан.<br>Монгол Улсын Засгийн газраас Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.<br><br>Мөн Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 2 дугаар хуралдааны 4.4 дүгээр тэмдэглэлээр "... төрийн үйл ажиллагааны чанар, үр дүнг сайжруулах, хүнд суртлыг багасгаж, шат дамжлагыг цөөлөх, чиг үүргийн давхардал, хийдлийг арилгах зорилгоор яамны стратегийн бодлого төлөвлөлт, хэрэгжилтийг зохицуулах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх болон бусад шаардлагатай чиг үүргийг хариуцах бүтцийн нэгж, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги | 2025.01.01<br>-<br>2025.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн төсөл ...”-ийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар яаралтай хэлэлцүүлэх үүрэг, даалгавар өгсөнтэй холбогдуулан уг үүрэг, даалгаварыг хэрэгжүүлэх зорилгоор “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулсан.<br>Засгийн газраас “Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 07 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн 12 дахь хэсэг, мөн тогтоолын 13 дугаар хавсралтаар баталсан “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-ийг баталсан. Үүний дагуу “Албан хаагчдыг ажлаас чөлөөлөх тухай” Төрийн нарийн бичгийн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | даргын 2025 оны Б/116 дугаар, “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны бүтцийн нэгжийн орон тоо, албан тушаалын жагсаалт батлах тухай” Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны Б/117 дугаар, “Албан тушаалд томилох тухай” Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны Б/118 дугаар, “Албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэх тухай” Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны Б/119 дүгээр тушаал болон “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны бүтцийн нэгжүүдийн чиг үүрэг, албан тушаалын чиг үүргийг шинэчлэн батлах тухай” Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны Б/130 дугаар тушаалуудыг тус тус боловсруулж, батлуулсан. Эдгээр тушаалууд гарсантай холбогдуулан Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны зарим албан хаагчдын Албан тушаалын тодорхойлолтын төслийг боловсруулж, Төрийн албаны зөвлөлөөр батлуулах үйл ажиллагаан мэргэжил, арга зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлж ажилласан.<br>Мөн “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын салбарын гадаад харилцаа, үйл ажиллагааны нэгдмэл | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байдлыг хангах журам"-ыг Гадаад хамтын ажиллагааны хэлтсээс боловсруулж, хянуулахаар ирүүлснийг хянаж, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж, эцэслэн боловсруулсан болно. | | |

Гурав.Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Арга хэмжээ 1.<br>Төрийн албаны зөвлөл болон эрхлэх асуудлын хүрээнд зохион байгуулагдаж байгаа сургалтууд хамрагдана. | Хамрагдсан сургалтын тоогоор | 4 | 4 | Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан сургалтууд (цахимаар болон танхимаар)-д тухай бүр хамрагдсан. | 2025.01.01<br>-<br>2025.12.31 | 100% |
| 2 | Арга хэмжээ 2.<br>Эрүүл монгол хүн хөтөлбөрийн хүрээнд спорт сургалт/тэмцээн уралдаанд хамрагдсан/амжилттай оролцсон байна. | Хамрагдсан/оролцсон тэмцээн, уралдааны тоогоор | - | - | "Дархан-Ус суваг" ХК-ийн ойн арга хэмжээ болон байгууллагын дотоод спортын тэмцээнд амжилттай оролцож, байгууллагын тэмцээний волейболын төрөлд алтан медаль авсан.<br>Сайдын нэрэмжит болон Засгийн газрын цом-2025 спортын арга хэмжээнүүдэд тус тус амжилттай оролцсон. | 2025.01.01<br>-<br>2025.12.31 | 100% |
| 3 | Бусад сургалтууд | Хамрагдсан сургалтын тоогоор | - | - | 1.Удирдлагын академиас 2025 оны 02 дугаар сарын 17-19-ний өдрүүдэд зохион байгуулсан "Төрийн байгууллагын стратегийн төлөвлөлт" сэдэвт сургалтад хамрагдан, амжилттай төгсөж, сертификат гардан авсан.<br><br>2.Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Берлин хотод Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгээс 2025 оны 06 дугаар сарын 01-07-ны өдрүүдэд зохион байгуулсан "Төслийн түншлэгч | 2025.01.01<br>-<br>2025.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | талуудын барилгын дулаан шинэчлэл, барилгын эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх, дулааны хэрэглээнд суурилсан үнэ тариф болон санхүүгийн тогтвортой механизмыг нэвтрүүлэх боломжийг нэвтрүүлэх, чадавхийг бэхжүүлэх нь" сургалтад амжилттай оролцож, сертификат гардан авсан. | | |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

Хуулийн хэлтсийн ахлах шинжээч | Ц.Батчимэг /.............................../ | 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдөр

*( Албан тушаал )* | *( Нэр, гарын үсэг )* | *( Огноо )*

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*8 дугаар хавсралт*

**ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ ХАРИУЦСАН АХЛАХ ШИНЖЭЭЧ ЦЭРЭНМИНЖИНГИЙН БАТЧИМЭГИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

**Байгууллагын нэр: Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам**

**Нэгжийн нэр: Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтэс**

**Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| **Стратегийн зорилт 4:** Төрийн захиргааны удирдлага, хүний нөөцийн манлайллыг хангах, эрх зүйн туслалцаа үзүүлэх, хууль зүйн зөвлөгөө өгөх, хууль тогтоомжийг боловсронгуй болгох | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 1.1.**“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн Зорилт 3.6-ын “3.6.1-д газрын харилцаа, хот байгуулалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хотуудын зэрэглэлийг тогтоосон байна.” гэж, “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний “2.1.1.9.Хот төлөвлөлтийн бичиг баримтыг боловсруулахад оршин суугч, аж ахуйн нэгжийн саналыг тусгах, хөрөнгө оруулалттай уялдсан хот байгуулалтын бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хууль, эрх зүйн шинэчлэлийн бэлтгэл ажлыг эхлүүлэх" гэж, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “4.2.4.3.Хот байгуулалт, барилга, газрын талаарх холбогдох хуулийн уялдааг сайжруулж, төлөвлөлтөд суурилсан хот байгуулалтын тогтолцоог бий болгон, хотын ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн төлөвлөгөөний дагуу газрын зөвшөөрлийг олгож, зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хуулийн хариуцлагыг чангатгана.” гэж заасан зорилтуудын хүрээнд салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлнэ. | 60 | 10 | 70 | |
| 2. | **Арга хэмжээ 1.2.**”Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.4.3.2-т “Нийслэлийн хүн амын төвлөрлийг тархаан байршуулах зорилгоор дагуул хотуудыг төлөвлөж, бүс | 60 | 10 | 70 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | нутгийг өндөр хурдны авто зам, эрчим хүч, инженерийн барилга байгууламжаар хангаж холбоно.” гэж, “Монгол Улсын Их Хурлаас баталсан ”Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 9.3.1-т “Улаанбаатар хотын төвлөрөл, суурьшсан нутаг дэвсгэрийн тэлэлт, хязгаарлалт, газар зохион байгуулалт, авто замын сүлжээ, нийтийн тээвэр, газар доорх орон зай гэх мэт шаардлагатай төлөвлөлтийг тооцон хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, мэдээллийн нэгдсэн системд холбон хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлнэ” гэж , “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн Зорилго 9-д ”Амьдрахад таатай, байгаль орчинд ээлтэй, хүн төвтэй ухаалаг хот болгон хөгжүүлнэ” гэж, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 1.1.1.1-д “"20 минутын хот" буюу нийгмийн дэд бүтцийн хүртээмжийг зохистой түвшинд хүргэх бодлогын баримт бичгийг боловсруулж, түүнд суурилсан "Нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 2040" болон бусад хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, батлуулна” гэж тус тус тусгасаны дагуу “Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлж, батлуулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлсэн байна. | | | | |
| 3. | **Арга хэмжээ 1.3.**УИХ-ын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын жагсаалтыг гаргаж, нэгтгэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тухай бүр хүргүүлнэ. | 57 | 10 | 67 | |
| 4. | **Арга хэмжээ 1.4.**Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын жагсаалтыг гаргаж, нэгтгэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тухай бүр хүргүүлнэ. | 60 | 10 | 70 | |
| 5. | **Арга хэмжээ 1.5.**Хянаж, дугаар олгосон захирамжлалын болон зохион байгуулалтын баримт бичгийн бүртгэлийг хөтлөнө. | 55,8 | 10 | 65,8 | |
| 6. | **Арга хэмжээ 1.6.**Хот байгуулалтын салбарт нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний шинээр болон шинэчлэн боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлнэ. | 60 | 10 | 70 | |
| 7. | **Арга хэмжээ 1.7.**Яамны дотоод үйл ажиллагаанд мөрдөх дүрэм, журам, гэрээг шинээр болон шинэчлэн боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах баримт бичгийг боловсруулах үйл | 57 | 10 | 67 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | ажиллагаанд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлнэ. | | | | |
| 8. | **Арга хэмжээ 1.8.**Бусад төрийн захиргааны төв байгууллагаас ирүүлсэн хууль, УИХ-ын тогтоол, Засгийн газрын тогтоолын төсөлд санал боловсруулж, хүргүүлсэн байна. | 57 | 10 | 67 | |
| 9. | **Арга хэмжээ 1.9.** Төрийн албаны зөвлөлийн Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны салбар зөвлөлийн гишүүний үүрэгт ажил | 57 | 10 | 67 | |
| **Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт** | | | | | |
| 1. | Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/28 "Сумын төвийн инженерийн дэд бүтэц, шугам сүлжээний 2 дугаар ээлжийн ажил (Төв аймаг, Эрдэнэ сум) арга хэмжээг зохион байгуулах Үнэлгээний хорооны гишүүн | 57 | 10 | 67 | |
| 2. | Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/33 дугаар тушаалаар байгуулагдсан Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах цогц хөтөлбөр (Өвөрхангай аймгийн Хужирт, Бат-Өлзий, Бүрд, Богд сум), (Увс аймгийн Баруунтуруун, Наранбулаг, Хяргас) төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийн сонгон шалгаруулах үүрэг бүхий Үнэлгээний хорооны гишүүн | 57 | 10 | 67 | |
| 3. | Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/29 дугаар тушаалаар байгуулагдсан XVIII.1.1.6 Сумын төвийн инженерийн дэд бүтэц, шугам сүлжээний ажил /Хөвсгөл, Цагаан уул сум/ төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үүрэг бүхий Үнэлгээний хорооны гишүүн | 60 | 10 | 70 | |
| 4. | Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/22 дугаар тушаалаар байгуулагдсан Азийн хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ""Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах төсөл (MOH-3244/3245)"-ийг хэрэгжүүлж дуусч байгаатай холбогдуулан Захиалагчийн техникийн хяналтын зөвлөх үйлчилгээний төлбөр" төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалтыг зохион байгуулах үүрэг бүхий Үнэлгээний хорооны гишүүн | 54 | 10 | 64 | |
| 5. | Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/18 дугаар тушаалаар байгуулагдсан "Дулааны шугам сүлжээний даралт өргөх насос станц №7-ын өргөтгөлийн барилга угсралтын ажил (Улаанбаатар, Хан-Уул дүүрэг) төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалтыг зохион байгуулах үүрэг бүхий Үнэлгээний хорооны гишүүн | 57 | 10 | 67 | |
| 6. | "Ажлын хэсэг байгуулах тухай" Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/81 дүгээр тушаалаар Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийн Санхүүгийн ажилтныг сонгон | 57 | 10 | 67 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | шалгаруулах үүрэг бүхий Үнэлгээний хорооны гишүүн | | | | |
| 7. | Сайд, Төрийн нарийн бичгийн дарга болон нэгжийн дарга нараас өгсөн бусад үүрэг даалгаварын талаар | 57 | 10 | 67 | |
| Дундаж оноо: | | | | 67,6 | |

**2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1. | Арга хэмжээ 1.<br>Төрийн албаны зөвлөл болон эрхлэх асуудлын хүрээнд зохион байгуулагдаж байгаа сургалтуудад хамрагдана. | 100 | 15 | |
| 2. | Арга хэмжээ 2.<br>Эрүүл монгол хүн хөтөлбөрийн хүрээнд спорт арга хэмжээ болон тэмцээн уралдаан, сургалтад хамрагдсан байна. | 100 | 15 | |
| 3 | Бусад сургалтууд | 100 | 15 | |
| **Дундаж оноо** | | | **15** | |

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Нэгжийн даргын үнэлгээ)

| № | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1. | Хандлага, ёс зүй | 7 | |
| 2. | Дүн шинжилгээ хийх | 7 | |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 7 | |
| 4. | Хариуцлагатай байдал | 7 | |
| 5. | Ажлын цаг ашиглалт | 7 | |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | | |
| 6. | Мэргэжлийн ур чадвар 1.Хууль тогтоомжийн төсөл боловсруулах | 7 | |
| 7. | Мэргэжлийн ур чадвар 2.Албан бичиг болон баримт бичгийн төсөл боловсруулах | 7 | |
| 8. | Мэргэжлийн ур чадвар 3.Эрх бүхий албан тушаалтнаас өгсөн үүрэг даалгаварыг үр дүнтэй, хариуцлагатай, гүйцэтгэл сайтай хийж, гүйцэтгэх болон зохион байгуулах, шинийг санаачлах | 7 | |
| 9. | Мэргэжлийн ур чадвар 4.Хууль хэрэглээний болон холбогдох бусад | 7 | |
| **Дундаж оноо** | | **7** | |

**4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Хамт олны үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Хамт олны үнэлгээ (0-8 оноо) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1. | Хандлага, ёс зүй | 8 |
| 2. | Багаар ажиллах | 8 |
| 3. | Харилцаа | 8 |
| **Дундаж оноо** | | **8** |

5. Гүйцэтгэлийн үнэлгээ

| № | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)* | *67,6* |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | *15* |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ<br>*( Нэгжийн даргын үнэлгээ )* | *7* |
| 4. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ<br>*(Хамт олны үнэлгээ)* | *8* |
| 5. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт<br>*(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | *(..... оноо)* |
| **Нийт оноо =**<br>(Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)* ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | | 97,6 |

***Үнэлгээ өгсөн:*** ***Нэгжийн дарга***

Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /................................/ Б.Бат--Эрдэнэ

*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

*2025.12.05*

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:*** ***Төрийн жинхэнэ албан хаагч:***

Хуулийн хэлтсийн ахлах шинжээч ................................ /Ц.Батчимэг/

*2025.12.05*

***Үнэлгээг хянасан:***

*Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:*

Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /................................/ Б.Бат--Эрдэнэ

*2025 оны ... дугаар сарын ...-ны өдөр*

*Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:*

Яамны хүний нөөц, шагнал хариуцсан ахлах шинжээч /................................/ /Т.Янжмаа/

*2025 оны ... дугаар сарын ...-ны өдөр*

***Үнэлгээг баталгаажуулсан:*** ***Төсвийн шууд захирагч***

Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ................................ /М.БАЯРАА/

*2025 оны 12 дугаар сарын ...-ны өдөр*